



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA

**БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2026 о**

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
УДИРТГАЛ.....	4
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ.....	4
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох	4
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	6
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгож авах	7
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох.....	8
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	9
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.....	9
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	10
2.1. Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах	10
2.2. Судалгааны аргаар цуглуулсан мэдээлэл.....	12
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	14
3.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	14
3.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйл, 8 дугаар зүйл, 9 дүгээр зүйлд заасан банк бус санхүүгийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:.....	16
3.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйл, 13 дугаар зүйлд заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаанд хориглох зүйл, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	21
ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	22

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ББСҮАтХ	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалт
ХНО	Хөдөө орон нутаг
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЦТТМГ	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УДИРТГАЛ

Зах зээлийн чөлөөт эдийн засгийн харилцааг төлөвшүүлэх асуудлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг бол банк бус санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан иргэд, ААНБ-ын санхүүгийн хэрэгцээг хангах, бичил бизнесийг дэмжих, алслагдсан болон банкны үйлчилгээ авч чадахгүй байгаа бүлгийг санхүүгийн системд татан оролцуулахад оршдог.

Энэ ч утгаатраа УИХ-аас Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг 2002 оны 12 дугаар сарын 12 - ны өдөр 6 бүлэг 21 зүйлтэйгээр баталснаар банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, түүнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдэн, хууль хэрэгжсэнээс хойш 24 жилийн хугацаа өнгөрсөн байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт 2015 онд батлагдсан Хууль тогтоомжийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр “Аргачлал батлах тухай” тогтоолын 6 дугаар хавсралтад заасан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”¹ /цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

Үнэлгээг бие даасан, хараат бус байдлаар, судалгааны арга зүйг ашиглан хийж, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмаар гүйцэтгэсэн болно.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт "...хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно" гэж заасны дагуу Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох үүднээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу “хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”-г **төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх** гэсэн гурван үе шаттайгаар гүйцэтгэлээ.

Төлөвлөх шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Банк бус санхүүгийн байгууллага (цаашид “ББСБ” гэх)-ын салбар 1970-аад онд Бангладеш улсад эдийн засагч Мухаммад Юнус жижиг хэмжээний барьцаагүй зээлийн туршилтыг эхлүүлж, улмаар 1976 онд Грамин банкны загварыг бий болгосон нь орчин

¹ Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Аргачлал батлах тухай (2019)

үеийн бичил санхүүгийн хөдөлгөөний эхлэл болсон бөгөөд бичил санхүүгийн байгууллагын хөгжил нь уламжлалт банкны үйлчилгээ авч чаддаггүй иргэдэд санхүүгийн үйлчилгээ хүргэх шинэ тогтолцоо үүссэн байна. Дэлхий дахинд ББСБ-ын үйл ажиллагааны анхны эрх зүйн зохицуулалт нь XIX зууны Европын зээлийн хоршооны хуулиудаас эхлэлтэй бөгөөд харин бичил санхүүгийн байгууллагыг тусгайлан зохицуулсан хууль тогтоомжууд 1970–1990-ээд оноос эрчимтэй хөгжиж эхэлсэн байна.

Монгол Улсад энэ төрлийн санхүүгийн үйлчилгээний институт 1990 оноос эхлэн бүрэлдэн хөгжсөн бөгөөд УИХ-аас 2002 онд эрх зүйн зохицуулалттай болгосноор эдүгээ 578 ББСБ 9 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 603 салбар нэгж, 10 төлөөлөгчийн газар, 6,866 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.3 сая харилцагчид үйлчилгээ үзүүлж, 3.5 сая зээлдэгчид /давхардаагүй 768,150/ хүрч үйлчилж байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулиар банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, түүнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан байдаг.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль /цаашид “ББСҮАтХ” гэх/ нь 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдаж, бусад хууль тогтоомжийг дагаж 13 удаа /2005, 2006, 2009, 2010, 2011, 2015, 2017, 2022, 2023, 2024 он/ нэмэлт өөрчлөлт орж байсан боловч өнөөдрийг хүртэл нэг ч удаа хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээгүй байна.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.2.2-т “хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хуулийн эрх зүйн зохицуулалт бодит байдалтай нийцээгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүйгээс сөрөг үр дагаварууд бий болсон”, “3.2.3-т “захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл үүсэх болсон”, зэргийг харгалзан хэрэгжилтийн үр дагаварт нь үнэлгээ хийх шаардлага үүссэн.

Эрх зүйн орчны хувьд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх боломж нөхцөлийг хуулиар бүрдүүлсэн хэдий ч амьдралд шинэ тутамд бий болж буй бүтээгдэхүүн үйлчилгээний цахим хөгжил, даяаршлын хөгжлийн чиг хандлагаас хоцорч, практикт байгаа зохицуулалт дутмаг эрх зүйн харилцааг судлан үзэж, хуулийн зохицуулалт зорилгодоо хүрч чадаж байгаа эсэхийг судлан тогтоохыг зорьлоо.

Уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийж буй үнэлгээ нь хуулийн ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход чиглэгдэхийн зэрэгцээ хуулийг хэрэгжүүлэх явцад орхигдсон, давхардсан, цаг үеэ олоогүй зохицуулалтыг тодорхойлоход чиглэгдсэн болно.

ББСҮАтХ хэрэгжиж эхэлснээс хойших хугацаан дахь нийгмийн харилцаа болон төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, үйл ажиллагааны өөрчлөлт, хөгжлөөс шалтгаалан тус хуулийн зохицуулалтыг олон улсын чиг хандлагад нийцүүлэн

өөрчлөн шинэчлэх, хэрэгжүүлэхэд ээдрээ түвэгтэй, нэг мөр ойлгож, хэрэглэхэд хүндрэлтэй зарим зохицуулалтуудыг засаж сайжруулах, хуулийн үйлчлэх хүрээг шинээр авч үзэх бодит хэрэгцээ үүсэж байна.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийн байдлыг сонгож авсан зохицуулалтын хүрээнд үнэлэх бөгөөд Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д заасны дагуу “Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” гэснийг удирдлага болгов.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд ихээхэн цаг хугацаа, хөдөлмөр цаг, зардал шаардагдах ба хуулийн зорилтийг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх зарим зохицуулалтыг тусгайлан сонгож үнэлгээ хийх нь үр дүнтэй байх учир ББСҮАтХ-ийн хэрэгжилтийг үнэлэх хүрээг дараах байдлаар тогтоолоо.

Д/д	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, хэсэг
1	Нэг. Нийтлэг үндэслэл	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
2	Хоёрдугаар бүлэг Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх	7 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа
		8 дугаар зүйл. Бүрдүүлэх баримт бичиг
		9 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
3	Гуравдугаар бүлэг Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл, тавих шаардлага	12 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл
		13 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага

Үнэлгээ хийх явцад урьдчилан тогтоосон үнэлгээний хүрээг өргөжүүлэх, эсхүл багасгах нөхцөл байдал үүсч болно.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгож авах

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг тогтоохдоо Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6-р хавсралтын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг бодитойгоор илэрхийлж чадах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзан сонгов.

Аргачлалын дагуу шалгуур үзүүлэлтүүдээс

- зорилгод хүрсэн түвшин
- практикт нийцэж байгаа байдал
- хүлээн зөвшөөрөгдсөн байдал гэсэн 3 шалгуур үзүүлэлтийг үнэлгээний хамрах хүрээнд тухайн зохицуулалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой гэдгийг харгалзан үзэж сонгож авсан болно.

1.3.1 “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

ББСҮАТХ-ийн 1.1-д хуулийн зорилтыг “Энэ хуулийн зорилт нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, түүнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон.

Үүнээс үзвэл, ББСҮАТХ нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, банк бус санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой тусгайлсан харилцааг зохицуулахад чиглэсэн болох нь харагдаж байна. Иймд уг зорилтыг хангахтай холбоотой банк бус санхүүгийн үйл ажиллагаа бүрийн онцлог, иргэн хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг тодорхойлох зорилгоор 4, 19 дүгээр зүйлийг сонгож авлаа.

Д/д	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, хэсэг	Шалгуур үзүүлэлт
1	Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал
2	Хоёрдугаар бүлэг Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх	7 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа	Практикт нийцэж байгаа байдал
		8 дугаар зүйл. Бүрдүүлэх баримт бичиг	
		9 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	
3	Гуравдугаар бүлэг Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл, тавих шаардлага	12 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл	Практикт нийцэж байгаа байдал
		13 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага	

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг.

ББУАТХ-аар ББСБҮ эрхлэх этгээдээс иргэн, аж ахуйн нэгж байгууллагад санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоосон бөгөөд хууль батлагдаад 24 жилийн хугацаа өнгөрсөн хэдий ч цаг үеийн нөхцөл байдалтай уялдан өөрчлөлт шинэчлэлт, шаардлагатай зохицуулалт дутмаг байна.

Судалгааны энэ хэсэгт “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагатай холбоотой 7-9, 12, 13 дугаар зүйлийг сонгож авлаа.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

1. Байх ёстой болон одоо байгаа;
2. Хууль тогтоомж батлагдахаас өмнө болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
3. Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
4. Тохиолдол судлах.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний үндэс нь судалж буй зохицуулалтын талаарх ажиглагдаж буй болон хэмжиж болохуйц мэдээллийг цуглуулж, түүний зарим үзүүлэлтийг хооронд нь харьцуулах явдал бөгөөд эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практикт тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаан дээр үндэслэнэ.

Өөрөөр хэлбэл, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас нь үнэлэх учир дутагдалтай тул өмнөх үе шатанд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрд тохирсон харьцуулах хэлбэрийг сонгон үнэлгээ хийх болно.

ББСУАТХ-ийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг үнэлэх сонгож авсан «зорилгод хүрсэн түвшин», «практикт нийцэж байгаа байдал», «хүлээн зөвшөөрөгдсөн байдал» шалгуур үзүүлэлтүүд нь хууль хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дагавар нь анх хуулиар тавьсан зорилгоо хангаж чадаж байгаа эсэхийг харьцуулах аргаар буюу уг хуулийг хэрэгжүүлэгч чиг үүрэг бүхий байгууллагын тайлан, статистик, шүүхийн шийдвэр, судалгааны бүтээл зэрийг ашиглан тодорхойлох ба харин хуулийн практикт хэрэгжиж буй байдлыг үнэлэхдээ хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацааг «харьцуулалтын арга»-ын тусламжтайгаар, «хүлээн зөвшөөрөгдсөн байдал»-ыг хууль хэрэгжиж эхэлснээс хойших тоо баримтыг «байх ёстой болон одоо байгаа» гэсэн харьцуулалтын аргыг ашиглан тус тус тогтооно.

Дээрх харьцуулалтын хэлбэрийн хүрээнд ББСУАТХ-аар тогтоосон эрх зүй, зохион байгуулалтын үндэс нь өнөөгийн өөрчлөгдөн буй эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, хөгжлийн хандлагад нийцэж байгаа эсэх, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хэрхэн зохицуулж байгаа болон уг хуулийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг судалж тогтоох юм.

Д/д	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, хэсэг	Харьцуулах хэлбэр
1	Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших
2	Хоёрдугаар бүлэг Банк бус санхүүгийн	7 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа	Тохиолдол судлал

	үйл ажиллагаа эрхлэх	8 дугаар зүйл. Бүрдүүлэх баримт бичиг	
		9 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	
3	Гуравдугаар бүлэг Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл, тавих шаардлага	12 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл	Тохиолдол судлал
		13 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага	

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, хэсэг, заалт бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтээ томъёолох ба ийнхүү томъёолохдоо ББСҮАТХ-аар зохицуулсан зүйл тус бүрийг шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавих бөгөөд таамаглал дэвшүүлэх болон асуулт тавихдаа аль болох товч, тодорхой томъёолох зарчим баримтлалаа.

Д/д	Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлтийн зорилго	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлтийн томъёолол
1	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших	Хуулийн зорилт хангагдаж чадсан уу? Хуулийн зорилт нь цаг үетэйгээ буюу практикт нийцэж байгаа эсэх? Хуулийн өнөөгийн зохицуулалт нь олон улсын чиг хандлагад нийцэж байгаа эсэх?
2	7 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа	Практикт нийцэж байгаа байдал	Тохиолдол судлал	ББСБ байгуулахад тавигдах шаардлага нь өнөөгийн нөхцөлд нийцэж байгаа эсэх? Тусгай зөвшөөрөл авсан ББСБ практикт хүлээн зөвшөөрөгдөж байгаа эсэх?
	8 дугаар зүйл. Бүрдүүлэх баримт бичиг			
	9 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл			
3	12 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл	Практикт нийцэж байгаа байдал	Тохиолдол судлал	Хуулиар заасан шаардлага өнөөгийн нөхцөлд нийцэж байгаа эсэх? Хуулиар тавигдсан шаардлага хангахад хяналт тавьж буй байдал ямар түвшинд байна вэ? Хүндрэл бэрхшээл байгаа эсэх?
	13 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага			

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээний хүрээ, тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр, томъёолсон шалгуур үзүүлэлтүүдээс хамаарч тоон болон чанарын мэдээллийг ашиглаж дараах мэдээлэл цуглуулах аргыг ашигласан болно. Үүнд:

- **Статистик, тоон мэдээ цуглуулах:** ББСБ-ын салбарт хийгдсэн болон бусад судалгааны тайлан, холбогдох статистик, тоон мэдээлэл, бусад эх сурвалжийг ашиглан дүн шинжилгээ хийв.

- **Холбогдох субъектүүдээс судалгаа авах.** ББСҮАТХ-ийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, Мэргэжлийн холбооны удирдлагатай уулзалт зохион байгуулж ярилцлагын аргаар анхан шатны болон нэмэлт мэдээлэл, тодруулга, тайлбарыг авсан. Түүнчлэн салбарын оролцогч, харилцагчтай уулзалт, ярилцлага зохион байгуулж, шаардлагатай чанарын болон тоон мэдээллийг цуглуулсан.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргыг ашиглан хэрэгжилтийн үе шатыг хийж гүйцэтгэв. Энэ үе шатанд холбогдох төрийн байгууллагатай уулзалт ярилцлага хийж, холбогдох тоо баримт, судалгааны ажил зэргийг судалж, ББСҮАТХ-ийн хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулав.

Ингэхдээ холбогдох байгууллагуудаас статистик, тоон мэдээг авч, үндэсний хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт, өмнө хийгдсэн судалгааны тайлангуудад дүн шинжилгээ хийлээ.

2.1. Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах

Статистик мэдээллийг цуглуулахдаа хуулийн зорилго, зохицуулалтын хамрах хүрээ болон үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдтэй уялдуулан сонгосон бөгөөд салбарын хөгжил, санхүүгийн тогтвортой байдал, зохицуулалтын хэрэгжилт болон санхүүгийн хүртээмжийг илэрхийлэх үндсэн үзүүлэлтүүдийг хамруулав.

ББСҮАТХ 2002 онд батлагдан гарснаас хойшхи хугацаанд банк бус санхүүгийн байгууллагууд нь Монгол Улсын санхүүгийн зах зээлд өөрийн орон зайг бүрдүүлж чадсан ба жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийг дэмжих, иргэдийн болон өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмрийг оруулж ирсэн байна.

2026 оны I улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 578 ББСБ байх ба эдгээрийн 100 нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 26 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ байна.

2026 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 44,439 хувьцаа эзэмшигчдийн 578 ББСБ, 603 салбар нэгж, 10 төлөөлөгчийн газар, 6,866 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.3 сая харилцагчид үйлчилгээ үзүүлж, 3.5 сая зээлдэгчид /давхардаагүй 768,150/ хүрч үйлчилж байна.


Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2022-I	2023-I	2024-I	2025-I	2026-I
Нийт ББСБ	529	514	531	575	578
Үүнээс: ХОН	85	94	95	96	100
Үүнээс: ГХО	28	25	24	28	26
Салбар	393	428	462	539	603

Төлөөлөгч	8	7	11	12	10
Хувьцаа эзэмшигчдийн тоо	21,778	28,353	33,850	35,807	44,439
Ажилчдын тоо	4,322	4,735	5,385	6,197	6,866
Харилцагчдын тоо	4,645,134	3,862,489	4,458,031	3,739,313	4,347,995
Зээлдэгчдийн тоо	3,862,489	1,297,025	1,800,942	2,581,334	3,467,471

2026 оны I улирлын байдлаар ББСБ-уудын нийт актив банкны салбарын нийт активын 11.3 хувьтай, нийт зээлийн үлдэгдэл 17.0 хувьтай тэнцэж байна. Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2022 оны I улиралд 2,972.8 тэрбум төгрөг байсан бол 2026 оны I улирлын байдлаар 3.2 дахин өсөж 9,570.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 1 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)




Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 23.6 хувь буюу 1.6 их наяд төгрөгөөр өсөж 2026 оны I улирлын байдлаар 8.1 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 505.6 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 7.6 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сүүлийн жилүүдэд цахим технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ гүнзгийрэн хөгжиж байгаатай холбогдуулан тус салбарт финтек зээлийн бүтээгдэхүүн зах зээлд нэвтэрч, иргэдийн богино хугацааны санхүүгийн хэрэгцээг хангах болсонтой холбогдуулан финтек технологид суурилсан хэрэглээний зээлийн хувьд 3.2 сая зээлдэгчийн 2.6 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 92.0 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 34.0 хувийг бүрдүүлж байна.

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар буюу 2.0 их наяд төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 37.6 хувийг өр төлбөрийн өсөлт, 62.4 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал 2026 оны I улирлын байдлаар салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2021 онтой харьцуулахад 3.5 дахин өсөж 5.1 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 7.3 дахин өсөж 4.4 их наяд төгрөгт хүрсэн байна.

Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал 2026 оны I улирлын байдлаар салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2021 онтой харьцуулахад 3.5 дахин өсөж 5.1 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 7.3 дахин өсөж 4.4 их наяд төгрөгт хүрсэн байна.

Зураг 2 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



Өөрөөр хэлбэл, ББСБ-ын салбар нь өөрийн хөрөнгөөрөө үйл ажиллагаа явуулах онцлогтой бөгөөд сүүлийн жилүүдэд энэ нь бусдын хөрөнгийг үр ашигтай удирдах чиглэлрүү хөгжиж, банкны эх үүсвэр, итгэлцлийн эх үүсвэр, өрийн бичгийн эх үүсвэр зэрэг олон төрлийн санхүүгийн хэрэгсэл ашиглах хандлага нэмэгдсэн байна.

2026 оны I улирлын байдлаар ББСБ-ууд 772.1 тэрбум төгрөгийн орлого олж, 500.2 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 271.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Хууль эрх зүйн акт

Монгол Улсын Үндсэн Хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992 он, №01

Иргэний хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002 он, №07

Компанийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2011 он, №42

Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагаан тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2021, №27

Валютын зохицуулалтын тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1994 он, №06

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2009 он, №28

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015 он, №28

Зөрчлийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №24

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №28

Зээлийн мэдээллийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2011 он, №45

Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам СЗХ 2025 №71 тогтоол

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам СЗХ 2025.02.25 №68 тогтоол

Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргахад мөрдөх журам СЗХ 2025.02.25 №68 тогтоол

Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоох тухай 2025.02.25 №69 тогтоол

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам 2023.12.08 А226/528 хамтарсан тушаал

2.2. Судалгааны аргаар цуглуулсан мэдээлэл

Хуулийн хэрэгжилтийн явцын талаар тандалтын судалгааг Санхүүгийн зохицуулах

хороо, Мэргэжлийн холбоо, холбогдох бусад эрх бүхий байгууллагын албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулж, мэдээлэл цуглуулсан болно.

СЗХ нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хуульд заасан үүргийн хэрэгжилтэд эрсдэлд суурилсан байдлаар зайны болон газар дээрх хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлж байна. Хяналт шалгалтын үйл ажиллагаа нь батлагдсан бодлого, журам, аргачлалд тулгуурлан хэрэгжиж, хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зах зээлийн тогтвортой байдлыг хамгаалахад чиглэгдэж байна.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд ББСҮАТХ-аас сонгож авсан үнэлэх зүйл, хэсэг, заалт бүрийг хэрэгжүүлэх үе шатанд олж авсан мэдээлэл дээр тулгуурлан үнэлнэ.

3.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Үнэлэх хэсэг 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Томъёолсон шалгуур үзүүлэлт

- Хуулийн зорилт хангагдаж чадсан уу?
- Хуулийн зорилт нь цаг үетэйгээ буюу практикт нийцэж байгаа эсэх?
- Хуулийн өнөөгийн зохицуулалт нь олон улсын чиг хандлагад нийцэж байгаа эсэх?

Банк бус санхүүгийн эрхлэх үйл ажиллагааны нэр томъёоллын хүрээнд:

Хуулийн 4.1.2-т **"факторингийн үйлчилгээ"** гэж зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах /шилжүүлэх/, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүрэн хариуцах үйл ажиллагааг гэж томъёолсон бөгөөд тухайн үйлчилгээгээр ямар санхүүгийн үйлчилгээ эрхлэх талаар тусгайлсан харилцааг нарийвчлан зохицуулаагүй байна.

Манай улсын хувьд Иргэний хууль тогтоомжид шаардах эрхийг шилжүүлэх, худалдах гэрээний нэг төрөл болохын хувьд пандектийн систем бүхий иргэнлэг эрх зүйн тогтолцооны зарчимтай холбоотойгоор факторингийн үйл ажиллагааг Иргэний хуулийн гэрээний эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах боломжтой гэж үзэн анх хуульчдагдаж, улмаар 2002 онд батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд санхүүгийн үйлчилгээний нэг төрөл хэмээн үзсэн.

Гэтэл нэр томъёоны тодорхойлолтоос үзэхэд факторингийн үйлчилгээний мөн чанарыг доройтуулж тодорхойлсон байх ба үйл ажиллагааны хүрээг оновчгүй тодорхойлсны улмаас энэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжих, жижиг дунд, үйлвэрлэл эрхлэгчдийн худалдааны эргэлтийг санхүүжүүлүүлэх хууль зүйн боломж хязгаарлагдмал байна.

"Факторингийн үйлчилгээ" нь үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч, шаардах эрх хүлээн авагч талын гурвалсан харилцаа бөгөөд факторингийн үйлчилгээ эрхлэгч нь авлагыг шилжүүлэн авч, үүрэг гүйцэтгүүлэгчид санхүүжилт олгох болон авлагатай холбогдуулан үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгчийн төлбөрийн чадварын талаар мэдээлэл олж авах, дүн шинжилгээ хийх, авлагын бүртгэл, данс хөтлөх, үүргийн гүйцэтгэлийг хангуулах явдал юм.

Гэтэл факторингийн үйлчилгээнд оролцогч талуудын эрх зүйн байдлыг оновчтой тодорхойлох хэрэгцээнээс эхлээд үйл ажиллагааны онцлог шинжүүдийг ижил төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээнээс ялгамжтай тодорхойлж, Иргэний хуулийн 123 дугаар зүйлд заасан шаардах эрх шилжихтэй холбогдсон харилцааг аж ахуйн хүрээнд эрхлэх, иргэн хоорондын харилцаанд үүсэх тохиолдлын шинжээр ялгамжтай тодорхойлж хуульчлах нь зүйтэй байна.

Нэгдсэн үндэсний байгууллагын олон улсын худалдааны хуулийн хороо (UNCITRAL) болон Хувийн хэвшлийн хуулийн зохицуулалтыг нэгтгэх олон улсын институт (UNIDROIT) нь олон улсын эрх зүйн стандарт тодорхойлох замаар зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх

чиглэлд ажилладаг байгууллагууд хамтран Факторингийн тухай загвар хууль (2023), Факторингийн тухай Конвенц (1988), Авлагын тухай Конвенц (2001) зэрэг баримт бичгүүдийг баталсан.

Факторингийн тухай загвар хууль нь хувийн эрх зүйн баримт бичиг бөгөөд факторингийн гүйлгээтэй холбоотой эрх, үүрэг, эрсдэл, давуу эрхийг тодорхой, урьдчилан таамаглах боломжтой болгох зорилготой бөгөөд энэхүү загвар хууль нь UNCITRAL-ийн Барьцаат хэлцлийн Загвар хууль (MLST) болон Авлагын тухай Конвенц зэрэг өмнөх олон улсын баримт бичгүүдтэй уялдсан, факторингт онцгойлон чиглэсэн, бие даасан эрх зүйн тогтолцоо санал болгож байна.

Сүүлийн жилүүдэд дэлхий даяар тархаж буй чиг хандлагаас харахад факторинг нь зохицуулалттай санхүүгийн үйл ажиллагаанд хамаарах шаардлагатай бөгөөд факторингийн үйл ажиллагааг тусгайлсан хууль тогтоомжоор зохицуулах чиг хандлага нэмэгдэж байна (IFC, 2023). Беларус, Украин, Иордан, Казахстан, Арабын Нэгдсэн Эмират зэрэг улсуудад факторингийн үйл ажиллагаанд зориулсан тусгайлсан хуулийн төслүүдийг боловсруулж эхлээд байна.

Иймд үндэстэн дамнасан худалдаа арилжааны эргэлтийн хөрөнгийг санхүүжилт, дотоодын худалдааны санхүүжилтийн урсгалыг олон улсын жишиг эрх зүйн баримтуудад нийцүүлэн зохицуулалтын оновчтой хэлбэрийг хуулиар тодорхойлох шаардлагатай.

Хуулийн 4.1.5-д "**цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ**" гэж бусдын мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, эсхүл интернет, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоог нь гүйцэтгэх ажиллагааг гэж тодорхойлсон байна

УИХ-аас 2017 онд баталсан Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.16-д "төлбөрийн үйлчилгээ" гэж бэлэн мөнгөний орлого, зарлага, шилжүүлэг хийх, төлбөр шилжүүлэх, төлбөрийн хэрэгсэл гаргах, хүлээн авах, мөнгөн гуйвуулга хийх, цахим мөнгө гаргах, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх болон Монголбанкнаас тодорхойлсон мөнгөн хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон бусад үйлчилгээг, 5.1.21-д "мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг" гэж харилцагчаас цахим төхөөрөмжийн тусламжтайгаар төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид хандаж эхлүүлсэн мөнгөн хөрөнгийн шилжүүлгийг, 5.1.22-д "мөнгөн гуйвуулга" гэж төлбөр шилжүүлэгч, төлбөр хүлээн авагчийн нэр дээр данс үүсгэлгүйгээр төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан мөнгөн хөрөнгө шилжүүлэх Монголбанкны зөвшөөрөлтэй эрхлэх үйлчилгээг тус тус тодорхойлсон байна.

Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т "Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ" гэж заасан бөгөөд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4.1.5-д заасан цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ", Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.16, 5.1.21., 5.1.22 дахь заалттай зөрчилдөж байна.

Иймд илүү нарийвчлан зохицуулсан хуулийн заалтыг хэрэглэх нь зүйтэй бөгөөд ББСҮАТХ-ийн 4.1.5 дахь хэсгийг хасах шаардлагатай.

ББСҮАТХ-ийн 4.1.6-д "**гадаад валютын гүйлгээ**" гэж гадаад валютыг худалдах, худалдан авах, түүгээр зээл олгох, баталгаа гаргах үйл ажиллагааг гэж заасан нь УИХ-аас 1994 онд баталсан Валютын зохицуулалтын тухай хуулийн 9.1-т "валют худалдах, худалдан авах, хадгалах, зээлдэх, шилжүүлэх, байршуулах, барьцаалах, улсын хилээр оруулах, гаргахтай холбоотой үйл ажиллагааг валютын гүйлгээ гэнэ" гэж заасантай утга агуулгын хувьд ижил байх тул Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т "Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ" гэж заасныг баримтлан уг хуулиар гадаад валютын арилжааны

үйл ажиллагааг тодорхойлох шаардлагагүй, хуулийн давхардал үүсгэж байна.

ББСҮАТХ-ын 4.1.8-д "богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх" гэж тодорхой гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийн эх үүсвэрийг нэг жил хүртэл хугацааны хөрөнгө оруулалтын үнэт цаас болон үүнтэй адилтгах санхүүгийн хэрэгсэлд хөрвүүлэхийг гэж заасан.

2026 оны I улирлын байдлаар 49 ББСБ 143.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Хөрөнгө оруулалтын 7.7 хувь буюу 11.1 тэрбум төгрөг нь хадгаламжийн сертификат, 92.3 хувь буюу 132.5 тэрбум төгрөг нь үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа гэдэг нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгө, мөнгөн эх үүсвэрийг ирээдүйд ашиг, орлого олох, хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, эдийн засгийн үр өгөөж бий болгох зорилгоор тодорхой хөрөнгө, төсөл, бизнес, үнэт цаас болон бусад хөрөнгөд байршуулахтай холбоотой үйл ажиллагаа байдаг.

Гэтэл цаг үеийн нөхцөл байдалтай уялдаагүйгээр богино хугацааны буюу 1 жил хүртэл хугацааны санхүүгийн хэрэгсэл худалдаж авахаар хязгаарлах нь нь хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, өгөөж зардлын түвшинтэй уялдаагүй байх ба хөрөнгө оруулалтын хэрэгслийн дундаж хугацаа 2.5 жил, өгөөжийн түвшин 8-11 хувь байгааг харгалзан урт хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах боломжийг хуулиар нээх нь зүйтэй байна.

Үүний зэрэгцээ хуулийн 13.4-т "Нөөцийн сан, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу хангаж биелүүлнэ" гэж заасны дагуу "зохистой харьцааны шалгуур үзүүлэлт" гэж юу болох, 8.1.7. тухайн банк бус санхүүгийн байгууллагын нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг дангаар эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн орлогын мэдүүлэг, дүрмийн санд оруулсан хөрөнгийн гарал үүслийн талаархи шаардлагатай мэдээлэл" гэж заасны дагуу нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гэдгийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д "нөлөө бүхий хувьцаа эзэмшигч" гэж тухайн компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны тав болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг" гэсэнтэй нийцүүлэн хууль зүйн ишлэл хийж тодорхойлох ба хууль хоорондын хийдлийг арилгах, хуулийн этгээдийн хэлхээ холбоог тодорхойлох "эцсийн өмлөгч"-тэй холбоотой зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй юм.

ББСБ-ын ирүүлсэн хүсэлт, мэдэгдэлд тулгуурладаг ба тухайлбал, хувьцаа эзэмшигчийн бүтэц, эзэмшлийн хувь хэмжээнд өөрчлөлт орсон тохиолдолд тухайн байгууллагын ирүүлсэн баримт бичигт үндэслэн эцсийн өмчлөгчийн мэдээллийг шинэчилэх харилцаа тусгагдаагүй буюу хязгаарлагдмал байна.

3.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйл, 8 дугаар зүйл, 9 дүгээр зүйлд заасан банк бус санхүүгийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Үнэлэх хэсэг	7 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа 8 дугаар зүйл. Бүрдүүлэх баримт бичиг 9 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none">• ББСБ байгуулахад тавигдах шаардлага нь өнөөгийн нөхцөлд нийцэж байгаа эсэх?• Тусгай зөвшөөрөл авсан ББСБ практикт хүлээн зөвшөөрөгдөж байгаа эсэх?

Банк бус санхүүгийн эрхлэх үйл ажиллагааны хүрээнд:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын I дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4 дүгээр бүлгийн 4.3 дахь зорилгод “Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ.” гэж тусгасан бөгөөд I үе шат (2021-2030 он)-нд “Бичил санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулан эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулж, үйл ажиллагааны хүрээг тэлсэн байна.”, II үе шат (2031-2040 он)-нд “Бичил санхүүгийн зах зээлийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн санхүүгийн салбарт эзлэх хэмжээг нэмэгдүүлсэн байна.”, III үе шат (2041-2050 он)-нд “Технологийн дэвшилд суурилсан бичил санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.” гэж тус тус тусгасан.

2012-2013 онд Хууль зүйн яамнаас “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуульд шинжилгээ хийж, хуулийн зохицуулалт сул, зөвшөөрлийн тоог бууруулах, бизнесийн таатай орчин бүрдүүлж, шинэчлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан байдаг.

ББСҮАТХ-ийн хүрээнд зохицуулах шаардлагатай асуудлыг тодорхойлох зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банк бус санхүүгийн байгууллагын холбоо, иргэд, аж ахуйн нэгж, ББСБ-уудыг оролцуулан санал асуулгыг цахимаар зохион байгуулсан бөгөөд асуулгын дүнгээс үзэхэд оролцогчдын 86.4 хувь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийг зах зээлийг өргөжүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэх чадамжгүй, үүсээд байгаа харилцааг бүрэн зохицуулж чадахгүй гэж дүгнэсэн байна.

ББСҮАТХ-ийн хамрах хүрээ, зохицуулалт өнөөгийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдал, санхүүгийн систем, салбарын зохицуулалт, хяналтын зарим харилцааг зохицуулахад хангалттай бус байна.

СЗХ-ны дүн мэдээллээс үзэхэд нийт ББСБ-уудын 88.9% нь буюу 514 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 55.9% нь буюу 323 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 167 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 28.9 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 63 ББСБ нийт ББСБ-уудын 11.1 хувийг бүрдүүлж байна.

2020-2024 онд нийт 171 этгээдээс банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлснээс 34 хүсэлтийг, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, бүтцэд өөрчлөлт оруулах 1,065 хүсэлт ирүүлснээс 63 хүсэлтийг тус тус шаардлага хангаагүй үндэслэлээр татгалзаж шийдвэрлэсэн байна.

Одоо мөрдөгдөж буй Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч нь нэр бүхий 9 төрлийн үйлчилгээг тусгай болон энгийн зөвшөөрлийн дагуу эрхлэх боломжтой ба банк бус санхүүгийн байгууллагуудын эрхэлж буй үйл ажиллагаа нь төрөл, эрсдэлийн түвшин, хүлээх үүрэг хариуцлагын хувьд ялгаатай хэдий ч нэгдсэн зохицуулалтад хамрагдаж, нийтлэг шаардлагуудыг мөрдөж ажилладаг.

Төрөөс бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор тусгай зөвшөөрлийн тоог бууруулах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж байгаатай уялдуулан өөр хоорондоо харилцан хамаарал бүхий тусгай зөвшөөрлүүдийг багцлан инистутчлэн хөгжүүлэх бодлого баримтлах, энэ хүрээнд тусгай зөвшөөрөлд тавигдах шалгууруудыг үйлчилгээний онцлогтой уялдуулан ялгамжтай байдлаар тодорхойлох нь зохимжтой буюу үйл ажиллагааг нь зохицуулсан харилцаа дутмаг байна.

Сүүлийн жилүүдэд ББСБ-ууд зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хүрээнд “Санхүүгийн түрээс”-ийн үйл ажиллагаа эрхлэх хандлага нэмэгдсэн буюу автомашин, утас,

цахилгаан барааны лизингийн үйлчилгээ гүнзгийрч байна.

Түүнчлэн Банкны тухай хуулийн 6.1.10-д санхүүгийн түрээсийн үйл ажиллагааг МБ-ны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлж болохор заасан байх ба энэ төрлийн үйлчилгээг эрхлэх нийгмийн шаардлага ББСБ-уудад байгаа хэдий ч үйл ажиллагааны нэр төрөл хязгаарлагдмал байна.

Иймд санхүүгийн түрээсийн үйл ажиллагааг эрхлэх хууль зүйн боломжийг санхүүгийн зуучлалын институтуудад эрх тэгш олгох нь зохимжтой байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагын хувьд:

Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар үйл ажиллагаанд тавигдах нийтлэг болон тусгайлсан шаардлагыг журамласан байна:

Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд тавиг нийтлэг шаардлага:

- банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн дүрэм, үйл ажиллагаа эрхлэхэд мөрдөх эрх зүйн баримт бичиг, үйлчилгээний нөхцөл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан байх,
- эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигчээс оруулах мөнгөн хөрөнгө нь бусдын өмнө үүрэг хүлээгээгүй, тухайн этгээд, түүнтэй холбогдох этгээдийн хууль ёсны орлогоор бүрдүүлсэн, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнасан орлого байх,
- Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх,
- гүйцэтгэх захирал нь томилогдсоноос хойш 6 сарын дотор банк бус санхүүгийн чиглэлээр эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх,
- банк бус санхүүгийн үйл ажиллагааг дэвшилтэт технологийн шийдлийг ашиглан үзүүлэх тохиолдолд хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан холбогдох шаардлагыг хангаж, ISO/IEC27001 стандартын гэрчилгээ авсан байх;
- банк бус санхүүгийн үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү, шимтгэл, хураамжийн хэмжээг баталсан байх. зэрэг шаардлага нь зах зээлд нэвтрэн орох сонирхогч иргэн хуулийн этгээдэд тавигдах хуулиар зохицуулах шаардлагатай харилцааг захиргааны актаар зохицуулж байх ба нийтлэг шаардлагыг ББСҮАТХ-ийн 9.1 дэх хэсэгт нэмж тусгах шаардлагатай байна.

2.2.Банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээнд дараах үзүүлэлтийг баримтална:

- Иргэний хуулийн 123 дугаар зүйлийг удирдлага болгон бараа, ажил, үйлчилгээ худалдах, худалдан авах гэрээнээс үүсэлтэй богино хугацааны авлагыг гэрээ эсхүл нээлттэй дансны нөхцөлийн үндсэн дээр үүрэг гүйцэтгүүлэгч нь мөнгөн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхээ факторингийн үйл ажиллагаа эрхлэгчид шилжүүлэх, факторингийн үйл ажиллагаа эрхлэгч нь үүрэг гүйцэтгүүлэгчид санхүүжилт олгох;
- факторингийн үйл ажиллагаа нь баталгаатай буюу буцаан дуудах нөхцөлтэй, баталгаагүй буюу буцаан дуудах нөхцөлгүй, урвуу гэсэн төрөлтэй байх;
- буцаан дуудах нөхцөлтэй факторингийн үед үүрэг гүйцэтгэгч авлагыг хугацаандаа төлөхгүй байх эрсдэлийг үүрэг гүйцэтгүүлэгч хариуцах ба үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч гүйцэтгээгүй үүргийн хэмжээгээр төлбөрийг факторингийн үйл ажиллагаа эрхлэгчийн өмнө хариуцаж, ийнхүү гүйцэтгэсэн даруй факторингийн үйл ажиллагаа эрхлэгч нь шаардах эрхийг үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан шилжүүлэх;
- буцаан дуудах нөхцөлгүй факторингийн үед гэрээгээр шилжүүлсэн авлагыг үүрэг гүйцэтгэгч хугацаандаа төлөхгүй байх эрсдэлийг факторингийн үйл ажиллагаа эрхлэгч

- хариуцах;
- урвуу факторингийн үед факторингийн үйл ажиллагаа эрхлэгч болон үүрэг гүйцэтгэгч хооронд байгуулсан тусгай гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн мөнгөн төлбөрийн үүргийг түүний даалгавар, эсхүл үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлтээр факторингийн үйл ажиллагаа эрхлэгч үүрэг гүйцэтгүүлэгчийг санхүүжүүлсний хариуд үүрэг гүйцэтгүүлэгчээс авлагыг шилжүүлэн авч, үүрэг гүйцэтгэгч факторингийн үйл ажиллагаа эрхлэгчийн өмнө төлбөрийг хариуцах;
- гэрээнд өөрөөр заагаагүй бол, үүрэг гүйцэтгүүлэгч нь факторингийн гэрээ байгуулсан даруй авлагыг факторингийн үйл ажиллагаа эрхлэгчид шилжүүлсэн тухайгаа үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэх ба мэдэгдэлд авлага үүсэх үндэслэл болсон гэрээний талаарх мэдээлэл, факторингийн үйл ажиллагаа эрхлэгчийн талаарх мэдээллийг тусгасан байх;
- үүрэг гүйцэтгүүлэгч нь факторингийн үйл ажиллагаа эрхлэгчид энэ журмын 2.2.6-д заасан мэдэгдэл, нэхэмжлэлийг баталгаажуулсан болон харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт бичгийг хүргүүлдэг байх;
- Факторингийн үйл ажиллагаа эрхлэгч нь шаардах эрхийг хүлээн авахдаа үүрэг гүйцэтгэгчийн санхүүгийн байдал, төлбөрийн чадвар, зах зээлд өрсөлдөх чадварыг үнэлсэн байх;
- үүрэг гүйцэтгэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг үндэслэлгүйгээр ихэсгэхгүй байх;
- факторингийн гэрээгээр шилжүүлэн авсан авлагын тухай мэдэгдлийг Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасны дагуу бүртгүүлж болно.

Тухайлбал, Факторингийн үйл ажиллагаа нь жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн үүргийг санхүүжүүлэх, өртөг зардал багатай санхүүжилтийн урсгалаар үйл ажиллагааны тасралтгүй байдлаа хангах өргөн хүрээний ач холбогдолтой хэдий ч эрх зүйн орчин дутмаг байгаагийн улмаас нийгэмд үүсээд байгаа санхүүгийн харилцааг гагцхүү дээрх нэр томъёоны хүрээнд зохицуулахад ихээхэн хүндрэл бэрхшээл үүсээд байна.

Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид өнөөгийн хүлээгдэж буй мөнгөн төлбөрийн үүргийг гагцхүү банк, санхүүгийн зээлийн үйлчилгээгээр л санхүүжүүлж байгаа нь аж ахуйн нэгжүүдээс цаг хугацаа, эх үүсвэр олж бэлтгэх хийгээд хүүгийн зардал, барьцаа хөрөнгийн шаардлага зэрэг ихээхэн хүчин чармайлт шаардаж, бизнесийн орчин тэлэх суурь боломжийг хязгаарлаж байна.

2025 оны жилийн эцэст үйлчилгээ эрхлэгчдийн тоо 64-д (арилжааны 4 банкыг оруулсан дүнгээр) хүрсэн хэдий ч 27 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй байх ба 33 ББСБ-ын факторингийн тооцооноос үүссэн авлага 107.4 тэрбум төгрөг байгаа нь шаардах эрхийг шилжүүлэхтэй холбоотой эдийн засгийн харилцаа төдийлөн зах зээлд үүргээ гүйцэтгэхгүй байна.

Олон Улсын Факторингийн холбооноос факторингийн үйл ажиллагаа нь эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг уламжлалт банк санхүүгийн зээлийн бүтээгдэхүүнээс ялгаатайгаар бодит худалдааны гүйлгээ, нэхэмжлэлд суурилан санхүүжилт олгодог ороо онцлог тул банк, санхүүгийн байгууллагын уламжлалт зээлийн сувгийг орлох бус, харин эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн сегментэд чиглэсэн, санхүүгийн зах зээлийн бүтцийн төрөлжилтийг дэмжих, олон улсын хэмжээнд жижиг, дунд бизнесийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдлыг хангах чухал санхүүгийн хэрэгсэлд тооцогдож байна.

Төр болон томоохон корпорацууд нийлүүлэлтийн сүлжээндээ олон тооны жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулдаг эдийн засгийн бүтэцтэй улс орнуудад факторинг нь нийлүүлэлтийн сүлжээний эрсдэлийг бууруулах, үйлдвэрлэл, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах бодлогын ач холбогдолтой хэрэгсэл болж хөгжсөн байдаг.

Олон улсын туршлагаас харахад нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн платформоор жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтийн 20–25 хувийг нэхэмжлэлд суурилсан, богино хугацаат санхүүжилтээр орлуулах боломжтой гэж үзэж байна.

2.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс төлбөрийн баталгаа гаргахад Иргэний хуулийн 234, 457, 458 дугаар зүйлийг баримтална.

2.4. Банк бус санхүүгийн итгэлцлийн үйл ажиллагаанд дараах үзүүлэлтийг баримтална:

- өөрийн хөрөнгийг итгэлцлийн үйлчилгээ эрхлэгчид шилжүүлж, түүнээс гарах үр шимийг өөрөө хүртэх, эсхүл хувь хүртэгчид хүртээх зорилго бүхий иргэн, хуулийн этгээд (цаашид “итгэмжлэгч” гэх)-ийн актив хөрөнгийг итгэлцлийн үйлчилгээний хүрээнд хянах, ашиглах, захиран зарцуулах доод хугацаа зургаан сараас доошгүй байх ба итгэлцлийн үйл ажиллагаанд Иргэний хуулийн 406 дугаар зүйлийг баримтлах;
- харилцагчийг татах зорилгоор бэлэг, урамшуулал санал болгох, үр шимийн хувь хэмжээг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан түгээх, өөрийн үйл ажиллагааны үр дүнг худал мэдээлэх, төөрөгдөлд оруулахуйц аливаа үйлдэл гаргахгүй байх;
- гэрээний дагуу итгэмжлэгдсэн хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагаатай холбогдох бүртгэл, тайлан болон бусад шаардсан мэдээллийг итгэмжлэгчид үнэн зөв гаргаж өгөх, итгэмжлэгчээс шилжүүлэх мөнгөн хөрөнгийн гарал үүслийг тодорхойлох ажиллагааг хэрэгжүүлэх;
- компанийн засаглалын кодекст заасан холбогдох шаардлагыг хангах.

2.5. Банк бус санхүүгийн богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаанд дараах үзүүлэлтийг баримтална:

- төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа алдагдуулахгүйгээр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан санхүүгийн хэрэгсэл, Засгийн газар болон Төв банкны үнэт цаасанд хөрөнгө оруулах;
- гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийн эх үүсвэрийг нэг жил хүртэл хугацаатай энэ журмын 2.5.1-т заасан санхүүгийн хэрэгсэлд хөрвүүлэх;
- иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийн эх үүсвэрийг гэрээний үндсэн дээр хөрвүүлэхдээ хөрөнгө оруулалтын хэлбэр, хүртэх үр шим, эрсдэлийг харилцан тохиролцсон байх;
- өөрийн эзэмшиж буй үнэт цаасыг арилжааны зөрүүгээс ашиг олох зорилгоор худалдаж болно.

2.6. Өөрийн хөрөнгөөр буюу бусдаас аливаа хэлбэрээр эх үүсвэр татан төвлөрүүлээгүй банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувьд энэ журмын 2.5 дахь хэсэг хамаарахгүй.

2.7. Банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаанд дараах үзүүлэлтийг баримтална:

- үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, техник, технологийн шаардлагыг хангасан байх;
- харилцагчийг таньж мэдэх, гүйлгээний бүртгэл хөтлөх, хадгалах, нууцлах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, сэжигтэй гүйлгээг мэдээлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналтын системтэй байх.

2.8. Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаанд дараах үзүүлэлтийг баримтална:

- ажлын байрны аюулгүй байдлыг хангасан байх;
- санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор дүрс бичлэгийн техник хэрэгсэлтэй байх ба дүрс бичлэгийг нэг сараас доошгүй хугацаагаар архивлан

- хадгалдаг хяналтын системтэй байх;
- валют шалгагч болон мөнгө тоологч машинтай байх;
- валютыг худалдан авах, худалдах ханшийг электрон самбар болон цахим талбараар нийтэд ил тод мэдээлдэг байх;
- Стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан шаардлагыг хангасан хаягтай байх;
- ажилтан нь мөнгөн тэмдэгийг тухай бүр хянах бөгөөд гүйлгээнээс хуурамч мөнгөн тэмдэгт илрүүлсэн тохиолдолд гүйлгээг зогсоож, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэн, биеийн байцаалтын мэдээллийн хамт холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгөх.

2.9.Бэлэн бусаар гадаад валютын арилжаа эрхлэх хуулийн этгээдийн хувьд энэ журмын 2.8.2-2.8.4 дэх заалт хамаарахгүй буюу хангаж ажилласанд тооцно.

2.10.Дээд зэрэглэлийн 5 ба 4 одтой зочид буудал нь өөрийн үйлчлүүлэгч болох Монгол Улсад жуулчлал хийж байгаа нэг гадаадын иргэнд өдөрт 3 сая төгрөгөөс ихгүй дүнгээр гадаад валют худалдан авах, худалдахад энэхүү журмын 2.8 дахь хэсэг хамаарахгүй.

Иймд тус журмын 2.2 дахь хэсэгт банк бус санхүүгийн факторинг, итгэлцэл, валютын арилжаа, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйлчилгээний байвал зохих зохицуулалтын суурь хэмжээг тогтоосон байгааг хуулиар зохицуулах шаардлагатай байна.

3.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйл, 13 дугаар зүйлд заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаанд хориглох зүйл, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Үнэлэх хэсэг	12 дугаар зүйл.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл 13 дугаар зүйл.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Хуулиар заасан шаардлага өнөөгийн нөхцөлд нийцэж байгаа эсэх? • Хуулиар тавигдсан шаардлага хангахад хяналт тавьж буй байдал ямар түвшинд байна вэ? Хүндрэл бэрхшээл байгаа эсэх?

Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг хуулийн 12 дугаар зүйлд заасан бөгөөд зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэх, өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх, иргэн, хуулийн этгээдээс хадгаламж авах, хадгаламжийн данс нээх, чек, карт, вексель зэрэг төлбөрийн хэрэгслээр хадгаламж авах, банк бус санхүүгийн байгууллагын тайлан тэнцэлд тусгаагүй эх үүсвэрийг өөрийн үйл ажиллагаанд ашиглах, Банк бус санхүүгийн байгууллага, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд гаргаж өгөх, задлах, ашиглах үйлдэл хийхийг тус тус хориглосон байна.

Банкны тухай хуулийн 17.4-д “Энэ хуулийн 17.5-д зааснаас бусад тохиолдолд банкны худалдан авах үнэт цаасны нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй бөгөөд нэг компанийн гаргасан хувьцааны 10 хувиас дээшгүй байна. Үүнд Засгийн газар, Төв банкны үнэт цаас, нийслэлийн үнэт цаас, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн хувьцаа хамаарахгүй” гэж заасан нь Компанийн тухай хуульд заасан хараат, охин компанитай байхыг хязгаарласан зохицуулалт бөгөөд энэ нь санхүүгийн тогтвортой байдал, ил тод байдлыг хангах, эрсдэлийн төвлөрөл болон мөнгө угаах эрсдэлийг бууруулах зорилгоор **хараат болон охин компанийн үйл ажиллагаанд**

хязгаарлалт тавьдаг. Ингэснээр санхүүгийн байгууллага үндсэн санхүүгийн үйл ажиллагаандаа төвлөрч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах нөхцөл бүрддэг.

Нөгөө талаас, охин компани алдагдал хүлээвэл толгой компанийн үйл ажиллагаанд шууд нөлөө үзүүлж, санхүү төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байдаг.

Түүнчлэн ББСҮАтХ-аар хуульд зааснаас өөр төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон атал охин компаниар дамжуулан бизнесийн бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх, охин компани байгуулах замаар үнэ шилжилт хийж, татвар төлөхөөс зайлсхийх хандлага ажиглагдаж байна. Гэтэл энэ төрлийн зохицуулалт ББСҮАтХ-д тусгагдаагүй байна.

Мөн Банкны тухай хуулийн 7.4.9-д **улс төрийн нам, эвсэлд хандив өгөхийг хязгаарласан** нь тухайн байгууллага үйл ажиллагаагаа улс төрийн нам, эвслийн нөлөө, удирдлага, ашиг сонирхлоос хараат бусаар явуулах, нам, эвслийн ашиг сонирголоос ангид байх, харилцагчдад намын харьяалал харгалзахгүйгээр тэгш үйлчилгээ үзүүлэх тэгш боломжийг олгох, шударга өрсөлдөөнийг дэмжих эерэг нөлөөтэй зохицуулалт бөгөөд ББСҮАтХ-аар энэ төрлийн харилцааг нээлттэй үлдээсэн байна.

Зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэсэн байдал:

Гомдлын агуулга	2024 он	2025 он	2026-И	Нийт
ЗМС ангилалтай холбоотой	48	82	34	164
Зээлийн гэрээний болон барьцаа хөрөнгийн маргаан	18	15	0	33
Зээлийн хүүгийн тооцоололтой холбоотой маргаан	6	17	7	30
ББСБ-ын ажилтны ёс зүйтэй холбоотой	1	5	2	8
Бусад маргаан	43	12	13	68
Нийт	116	131	56	303

Дээрх мэдээллээс харахад иргэний зээлийн мэдээлэл нийлүүлэлт, зээлийн гэрээний болон хүүгийн тооцоололтой холбоотой маргаан давамгайлж байх ба хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг шүүхийн өмнөх шатанд магадлан шийдвэрлэх харилцааг хуульчлаагүйгээс хуулийн байгууллагаар шийдвэрлэгдэж буй маргааныг төрөл, зардал, хөрөнгийг нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийн байдлыг үнэлсэн үнэлгээнээс дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон 2002 онд батлагдсан Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад салбарын хууль тогтоомж, эрх зүйн актаар зохицуулж байна.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт сонгож авсан зохицуулалтын хүрээнд үнэлгээ хийхэд банк бус санхүүгийн эрхлэх үйл ажиллагааг нэр томъёоллоос эхлэн үйл ажиллагааны хүрээнд хуулиар олгох боломж, эрх, үүрэг, хариуцлагыг дутмаг зохицуулсан байх ба хуулийн зохицуулалтын хувьд цаг үеийн шаардлагаас хоцрогдсон байх тул дараах өөрчлөлтийг оруулснаар хуулийн 50 -аас дээш хувьд нэмэлт өөрчлөлт

оруулах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зохицуулалт нь бүхэлдээ банк бус санхүүгийн эрхлэх үйл ажиллагааны хэм хэмжээг нарийвчлан зохицуулаагүй, эрх зүйн орчинг бүрдүүлэх бус зах зээлд нэвтрэн ороход чиглэсэн харилцааг зохицуулсан байна.
2. Банк бус санхүүгийн эрхлэх үйл ажиллагааны цар хүрээг хуулиар бүрэн тодорхойлж, хэм хэмжээний актаар зохицуулж буй харилцааг хуулиар зохицуулах замаар нэмж тусгах шаардлагатай.
3. Цахим технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ эрхлэх хууль зүйн боломжийг нээж, тэдгээрт тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналтын механизмыг оновчтой бүрдүүлэх шаардлагатай байна.
4. ББСБ, зээлдэгч, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, маргааныг урьдчилан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

-- оОо ---